



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 01 сарын 03-ны
өдрийн 6535 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А666

Улаанбаатар хот

Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.14, 27 дугаар зүйлийн 27.6, 38 дугаар зүйлийн 38.7, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


Б.ЖАВХЛАН

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН
Бүртгэлийн № 209
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Архивын эрхлэгч 
Нийт 45 хуудас 2023 оны 12 сар 28 өдөр

9763000851